

**Монгол улс ба Холбооны Бүгд Найрамдах Герман улс хоорондын
Санхүүгийн Хамтын Ажиллагаа**

**Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын
өөрчлөлтөд дасан зохицох төсөл
- 1, 2, 3 дугаар үе шат -**

KfW банкны хяналт үнэлгээ 10 дугаар сарын 11-16, 2021

Хурлын тэмдэглэл

2021 оны 10 дугаар сард Майкл Сумсер (KfW-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал) болон Цэвэгийн Энхзул (KfW-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын төслийн үндэсний зохицуулагч) нараас бүрдсэн KfW банкны үнэлгээний баг, **Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох** төслийн (БОЯБХУАӨДЗТ) 2021 оны явцын үнэлгээг хийлээ. Монгол орны зүүн зүгийн 3 бүс нутагт ажиллаж, төслийн 1, 2, 3 дугаар үе шатны хэрэгжилтийн талаар холбогдох талуудтай уулзаж ярилцав. БОАЖЯ-ны удирдах ажилтнууд, тухайлбал, үнэлгээний багт орж орон нутагт ажилласан ТХБНУГ (Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газар)-ын мэргэжилтэн Болдбаатар болон аймаг, сум, тусгай хамгаалалттай газар нутгийн бусад төлөөлөлтэй уулзалт, ярилцлага хийв. Үнэлгээний ажлыг ЗБ, ТХН болон төслийн зохицуулагч Г. Эрдэнэбаясгалан маш сайн зохион байгууллаа. Тус багийнхан Онон Балжийн улсын тусгай хамгаалалттай газар болон Чойбалсан, Дарьганга орчмын орон нутгийн хамгаалалттай газар нутгуудад ажиллаж, тусгай хамгаалалттай газрын удирдлагуудтай уулзав. Мөн Дорнод аймгийн Засаг даргын хамт тус бүсийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчдад мотоцикл гардуулан өглөө.

Хяналт, үнэлгээний үеэр хийсэн уулзалт ярилцлагууд туйлын таатай, өндөр үр бүтээмжтэй, ажил хэрэгч байдалтай үргэлжилсэн бөгөөд албаны хүмүүс болон уулзсан бусад бүх хүмүүсийн зочломтгой найрсаг байдал, дэмжлэгт талархаж буйгаа үнэлгээний баг илэрхийлсэн.

Энд дурдсан бүх мэдэгдэл, тайлбар нь зөвхөн үнэлгээний багийнхны байр суурийг илэрхийлнэ гэдгийг онцлов. Харилцан тохиролцсон саналуудыг KfW банкны удирдлага болон Германы Засгийн газар, мөн үүний нэгэн адил тэдгээрийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд батлах ёстой.

Үнэлгээний багаас гаргасан санал, үр дүнг доор харуулав.

1. Ерөнхий/хураангуй үнэлгээ

Үнэлгээний багийн зүгээс Төслийн I үе шатыг хэрэгжүүлэхэд томоохон ахиц дэвшил гаргасан БОАЖЯ, ТХН, Зөвлөх багт баяр хүргэж, төслийн ажлыг хэрэгжүүлэхэд талуудын тууштай байдал, мэргэжлийн ур чадвар сайн байгааг өндрөөр үнэлж байгаагаа илэрхийлэв. Төслийн 1 дүгээр үе шатыг 2021 оны эцэст БОЯБХУАӨДЗ төслийн I үе шатыг дуусгавар болгох гэрээний дагуу дуусгавар болгохоо бүх талууд илэрхийллээ. Тэр хугацаанаас өмнө, үндсэндээ, төлөвлөсөн болон хэрэгжиж буй ажлыг (үүнд, орчны бүсийг дэмжих ажил мөн орно) дуусгавар болгосон байх ёстой.

Төслийн үзэл баримтлал болон үр дүнгийн хувьд харахад ТХГН-ийн түвшинд тодорхой хэмжээний ахиц гарсан төдийгүй БОЯБХУАӨДЗ төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмж, дэд бүтэц нь томилолтын үеэр уулзсан ТХГН-ийн ажилтнуудын урам зориг, ёс суртахуунд ихээр нөлөөлсөн нь тодорхой анзаарагдаж байв. Харин, ТХГН-ийн Орчны бүсийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих ажилд (орчны бүсийн сангаас гадна, ОБС) төдийлөн дэвшил гараагүй байна.

2. Томилолт, хөрөнгө оруулалт

Өмнө хийсэн хяналт үнэлгээний үед онцолсны адил, KfW банкны Үнэлгээний баг олгогдсон бүх хөрөнгө оруулалтын ашиглалтын тогтвортой байдлыг хангахын тулд тогтмол засвар үйлчилгээ хийх шаардлагатай (2019, 2018 оны 6-р сар, 2017 оны 8-р сар, 2016 оны 9-р сард гарын үсэг зурсан ХТ-ыг харна уу), төсвийг БОАЖЯ хариуцна гэдгийг дахин сануулав. Байгаа мэдээллээс харахад ТХГН-н Хамгаалалтын Захиргаа бүр "засварын зардал"-ын (дэд бүтэц, хангамж) тусгай төсөвтэй бөгөөд энэ нь ХЗ-ны нийт төсвийн 1,0-10% хооронд хэлбэлздэг.

Энэхүү төсөв нь БОЯБХУАӨДЗ төслийн нэг хэсэг болгон санхүүжүүлсэн бараа, ажилд тусгайлан зориулагдаагүй болно. Хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлж буй бараа, ажил, үйлчилгээтэй пропорциональ шугамаар засвар үйлчилгээний төсвийг нэмэх шаардлагатай, мөн томилолтын явцад БОАЖЯ/ТХН-ээс тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээнд тогтмол хяналт тавихыг Үнэлгээний баг сануулав. 2019 онд БОАЖЯ/ТХН нь Зөвлөх багтай хамтран нийлүүлсэн хөрөнгө оруулалтын ашиглалт, засвар үйлчилгээний (АЗҮ) концепцыг боловсруулж, KfW банканд хүргүүлэхээр тохиролцсон хэдий ч өнөөг хүртэл энэ үзэл баримтлал нь Бэлтгэл шатандаа байсаар байна. Энэ нь төсөл дууссаны дараа АЗҮ-д шаардлагатай улсын төсвийн хэмжээг тооцож гаргах юм.

3. Хөтөлбөрийн менежмент

3.1. Хөтөлбөр үргэлжлэх хугацаа

БОЯБХУАӨДЗ төслийн I шатыг төлөвлөсний дагуу 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх буюу 2020 оны 5-р сард дуусгах нь бодитой бус байсан бөгөөд 2021 оны эцэс хүртэл сунгах шаардлагатай гэж бүх талууд үзсэн. Төслийн I шатыг сунгаснаар одоо хэрэгжиж байгаа ажлууд, үлдсэн тендерүүдийг гүйцэтгэх, ялангуяа загвар төслүүд болон орчны бүсийн үйл

ажиллагаатай холбоотой (ОБС-ээс гадна) тендер, бусад арга хэмжээг хэрэгжүүлэх хангалттай хугацаа юм. Үүнтэй холбогдуулан иргэдийн амьжиргаа дэмжих Орчны бүсийн сан (ОБС) (Төсөв 430,000.00 евро) болон орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих арга хэмжээнүүд нь төслийн үзэл баримтлалын чухал тулгуур гэдгийг Үнэлгээний багаас дахин онцоллоо. Орчны бүсийн сангийн зээл таван суманд хэрэгжиж эхэлсэн бөгөөд 21 хоногийн дотор бүгд гарч дууссан байна. Энэ зээлийг авах малчдын эрэлт төсөөлж байснаас харьцангуй их байсан тул ОБС-ийн зээлийг зөвхөн энэ 5 сумаар хязгаарлалгүй, цааш нь өргөтгөж, төлөвлөгөө гаргах шаардлагатай. KfW банкны Үнэлгээний баг болон Төслийн Зөвлөх баг олгосон зээлд эхний хяналт хийж, зээлийн нөхцөлийг нарийвчлан тохируулсны үндсэн дээр зээлийг өргөжүүлэхийг зөвлөв.

3.2. Үлдсэн төсвийг хуваарилах

2021 оны 10-р сарын 25-ны байдлаар Германы хөрөнгө оруулалтаас I үе шатанд нийт (11.5 сая евро) 10,947,536 еврог зарцуулсан (KfW банкнаас Төслийн тусгай данс руу шилжүүлсэн эсвэл зөвлөхөд төлсөн), II шатанд 1,426,638 еврог зөвхөн зөвлөх үйлчилгээнд зарцуулсан байна. I үе шатнаас зарцуулагдаагүй үлдсэн санхүүжилтийг (550,000 орчим евро) гэрээнд гарын үсэг зурагдсан ч хараахан санхүүжилт хийгээгүй, эсвэл тодорхой үйл ажиллагаанд зориулан хуваарилах байдлаар (боловсруулж/бэлдэж буй тендерүүд болон ОБС) нөөцөлсөн болно.

3.3. Монгол талын хөрөнгө оруулалт

Үнэлгээний багийн зүгээс ТХГН-т өгдөг тогтмол төсвөөс гадна БОАЖЯ/СЯ-ийг БоАЖЯ-ын Төслийн I-III үе шатны Санхүүжилт болон Тусгай гэрээнд заасан дүнтэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг гаргах Монгол Улсын Засгийн газрын үүргээ биелүүлэхэд анхаарах шаардлагатай байгааг онцоллоо.

2021 оны эцэс хүртэлх БОЯБХУАӨДЗ төсөлд МУ талын хөрөнгө оруулалт буюу 3,765 сая төгрөгийг (ойролцоогоор 2,152 сая евро) ТХН-ийн санхүүжилтэд зарцуулсан байна. Цаашлаад, МУЗГ-аас 2015-2021 оны хооронд ТХГН-ийн ашиглалт, засвар үйлчилгээ (О&М)-д зориулж 7,839 сая төгрөгийн (3,83 сая евро) санхүүжилт олгоод байна. Үнэлгээний баг 2020 онд огцом өссөн дүнг (+220%) сайшааж, 2020 оны өсөлт, мөн 2021 оны өсөлтийг төсөлд оруулсан МУ хөрөнгө оруулалт хэмээн хүлээн зөвшөөрч байна.

2019 оны ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг өсөлт тооцох үндэслэл болгон ТХН-ээс өгсөн мэдээлэлд суурилан KfW банк ашиглалт, засвар үйлчилгээний өсөлтийг 3,540 сая төгрөг (2,022 сая евро) гэж тооцжээ. ТХН-ийн зардал болон дээр дурдсан ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг нэмбэл Монгол Улс нийт 7,305 сая төгрөг (4,174 сая евро)-ийн хөрөнгө оруулалт хийжээ. БОЯБХУАӨДЗ төслийн I шатны Тусгай гэрээний дагуу Монголын талын хувь нэмрийг зөвхөн I үе шатанд 6.65 тэрбум төгрөг буюу 3.8 сая евро гэж төсөвлөсөн. I үе шатны хувьд санхүүгийн үүргээ сайн биелүүлж байна гэж үзэж байна.

Энэхүү амжилтыг Үнэлгээний баг өндрөөр үнэлэв. ТХГН-ийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээнд оруулах хувь нэмрийг төсөл дуустал жилээс жилд тогтмол нэмэгдүүлж,

санхүүжүүлсэн тоног төхөөрөмж, барилгуудыг сайтар ашиглаж, сайн авч явах, мөн II ба III үе шатанд хүлээсэн үүргээ тасралтгүй биелүүлэх шаардлагатайг Үнэлгээний багийн зүгээс онцлон тэмдэглэв.

3.4. Худалдан авалт, төслийн төсвийг шилжүүлэх (шилжүүлэхгүй), нэхэмжлэхийг төлөх (төлөхгүй)

БОАЖЯ болон СЯ-ны зүгээс МУ Засгийн газрын энэ жилийн төсөв хязгаартаа хүрсэн тул төлбөр хийхгүй гэдгээр шалтгаалан төлбөр тооцоог хааж, төслийн санхүүжилт хийгээгүй гэсэн тайлбарыг KfW банкны Үнэлгээний баг ямар ч байдлаар хүлээн зөвшөөрөх боломжгүй. 2021 онд хийгдэх худалдан авалт, сургалт, семинар болон төслийн бусад бүх үйл ажиллагаанд зориулж санхүүжилт гаргах тал дээр БОАЖЯ, СЯ хангалтгүй ажиллаж байна. Энэ нь төслийн үйл ажиллагаа, тэр дундаа Монгол Улсын Засгийн газарт итгэх итгэл, найдварт туйлын муугаар нөлөөлж байна.

Жишээлбэл, Төслийн Зөвлөх багийн тогтмол төлбөр нь СЯ-нд гарын үсэг зурагдаагүйгээс хэдэн сар хоцорч байна. Үнэлгээний багаас төлбөрийг хойшлуулах нь зохисгүй тул бүх төлбөрийг шилтүүлтэл ажлаа зогсоохыг Зөвлөх багт зөвлөсөн.

KfW банк, ТХН-ийн хүрээнд хэтэрхий удаашралтай байгаа худалдан авалтын үйл явцыг хэрхэн хурдасгах, Монголын тал болон KfW банкны талд зөвшөөрөл олгох үе шатнуудад шаардагдах хугацааг богиносгох арга замыг эрэлхийлсээр байна.

Тендер шалгаруулалтыг батлах гурван үе шат (тендер, үнэлгээ, гэрээ) тус бүрд, дараа нь төлбөр хийх бүрт 10-аас дээш гарын үсэг шаардлагатай болдог тухай ТХН хэлсэн. Энэ нь ажлын үр дүнтэй арга биш бөгөөд хялбарчлах шаардлагатай. БОАЖЯ, СЯ-ны төвөгтэй үйл явц нь зөвлөх үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн худалдан авах, барилгын ажил зэрэг бүгдэд нөлөөлдөг. Мөн тендерийн шат, дараа нь төлбөр төлөх бүрд адил байна.

Зөвлөх багийн төлбөрийн нэхэмжлэх нь зөвхөн хагас жилийн тайланг өгснөөр баталгаажихыг KfW банкны үнэлгээний баг тайлбарлав. Тиймээс, KfW банкны Үнэлгээний багаас БОАЖЯ болон KfW банк хооронд "Агентлагийн гэрээ" -г байгуулж, гарын үсэг зурах замаар одоо мөрдөж байгаа төлбөр шилжүүлэх журмыг хялбарчлахыг санал болгож байна.

Тус гэрээгээр БОАЖЯ зөвлөх багийн төлбөрийг шууд шийдвэрлэхийг KfW банканд хүлээлгэнэ. Агентлагийн гэрээ нь зөвлөх баг тогтмол төлбөрийн нэхэмжлэхээ KfW банканд шууд нэхэмжлэх боломжийг олгоно. KfW банк төлбөрийг шилжүүлэхээс өмнө төлбөрийн нөхцөлийг (тайлангийн хугацаа) шалгадаг. Энэ нь олон төслүүдийн ердийн практик бөгөөд энгийн журам юм.

Худалдан авалтын тухайд KfW банкны Үнэлгээний багаас Монгол талын төлбөртэй холбоотой үйл явцыг хялбарчлахыг онцгойлон анхаарууллаа. Бүх төлбөрийг тусгай данснаас хийдэг тул KfW банкны журмын дагуу БОАЖЯ/ТХН-ийн талаас нэг эрх бүхий хүн, Зөвлөх багаас нэг хүн тусгай данснаас төлбөр гаргах эрхтэй байхыг шаарддаг болохоос БОАЖЯ/ТХН/СЯ-ны 21 хүртэлх тооны хүн биш гэдгийг Үнэлгээний баг мэдэгдэв.

Үнэлгээний багаас "Дөрвөн нүдний зарчим" хэмээх банкны нийтлэг шийдлийг санал болгож байгаа бөгөөд энэ нь ТХН-ын зохицуулагч, БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нар

тусгай данснаас төлбөр гаргах эрхтэй байна. Нөгөөтэйгүүр, энэ хоёр хүн гарсан төлбөрт бүрэн хариуцлага хүлээнэ гэсэн үг. Одоогийн байдлаар хэт олон хүн оролцож, гарын үсэг зурдаг тул хэн ч хариуцлага хүлээхгүй байна.

4. Төслийн I үе шатны бүрэлдэхүүн хэсгүүд

Хөрөнгө оруулалтын ажил үргэлжилж байгаа бөгөөд ТХН нь 2021 онд өмнөх жилүүдийн дунджаас илүү өндөр хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна. 2020 онд эхлүүлсэн жорлонгийн барилгын ажил бараг дуусаж байна. Бусад тендерээс гадна ТХГН-ийн байгаль хамгаалагчдыг тээвэрлэх 4x4 автомашин (Оросын Фургон) худалдан авах тендер явагдаж байгаа бөгөөд 2021 онд дуусахаар байна. Хогны машин, хогийн сав худалдан авах ажил нь нэлээд удаан хугацаагаар хойшлогдоод байгаа тус тендерт ялсан Еврохан компаний хувьд ч мөн адил байна.

Орчны бүсийн сан (ОБС): Өмнө дурдсан бусад туршилтын төслүүдийн нэгэн адил ОБС нь үзэл баримтлалын хувьд өндөр ач холбогдолтой (хэдийгээр төсвийн хэмжээ нь бага ч гэсэн) гэдгийг Үнэлгээний баг онцлон тэмдэглэв. Түүнчлэн, ОБС нь Монгол Улсын байгаль орчны тулгамдсан асуудлын нэгт (бэлчээрийн даац хэтэрсэн, бэлчээрийн доройтол) анхаардаг. ОБС-ийн гарааны төсвийн хэмжээ 430.000 евро бөгөөд 5 суманд хэрэгжиж эхлээд байна. Тус сан нь бичил зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг Төрийн банктai хамтран хэрэгжиж байгаа юм. Сангийн дийлэнх зээлийг аль хэдийн олгосон. Хэрэв KfW банканд Орчны бүсийн санг дахин дүүргэх, өргөжүүлэх албан ёсны хүсэлт тавибал зөвшөөрөгдөх магадлалтай юм. ТХН болон Зөвлөх багийн зүгээс санг дахин дүүргэх, өргөжүүлэх хүсэлтийг бэлтгэж байна.

Нийгмийн дэд бүтэц: Томилолтын үед ажиглагдсан нэг зүйл нь төслөөс нийлүүлсэн түргэн тусламжийн машинууд ялангуяа Ковид-ийн үед сайн ашиглагдаж, үүргээ гүйцэтгэж байв. "Эко кабинет" (тавилга, сургалтын хэрэглэгдэхүүн) нь сургуулиуд нээгдсэнээс хойш бодитоор ашиглагдаж байна. Эдгээр хөрөнгө оруулалтыг ашиглах, засвар үйлчилгээ хийхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох яамдаас баталгаажуулах шаардлагатайг БОАЖЯ-д онцлон тэмдэглэж дуулгав.

I үе шатны бусад үйл ажиллагаа ба үнэлгээ:

Тус шатны ихэнх үйл ажиллагаа дууссан боловч хяналт үнэлгээ, олон нийтэд сурталчлах компанит ажил (хэвлэх материал), сургалт, семинар, нээлттэй хаалганы өдөрлөг, хаалтын үйл ажиллагаа гэх мэт шууд худалдан авалтаар шийдвэрлэх үйл ажиллагаанууд үргэлжлэн хийгдсээр байна.

5. Ерөнхий тайлбар:

- Худалдан авах ажиллагааны ажилтан, нягтлан бодогчийн тоог тус тус нэгээр цомхотгож, худалдан авалтын хэрэгжилт болон барилгын ажлын гэрээ хариуцсан гэрээт ажилтны орон тоог хоёроор нэмэгдүүлэн ТХН-ын багийн бүрэлдэхүүнд бага зэрэг өөрчлөлт оруулна гэж ТХН мэдэгдсэн. ТХН-ийн нийт ажилтны тоо 14 хэвээр байх болно. KfW банкны үнэлгээний багаас татгалзах зүйл байхгүй бөгөөд иймэрхүү жижиг өөрчлөлтийг Тусгай гэрээнд оруулах шаардлагагүй гэсэн.


- Улсын төсвөөс гадна ТХГН-ийн хэвийн үйл ажиллагаа болон засвар үйлчилгээнд хангалттай төсөв бүрдүүлэх нөхцлийг бий болгох замаар өөрсдийгөө санхүүжүүлдэг болоход БОАЖЯ анхаарах хэрэгтэйг Үнэлгээний баг онцоллоо. Үүний тулд ТХГН-ийн хууль тогтоомж, холбогдох журамд өөрчлөлт оруулах шаардлагатай. Боловсруулалт, хэлэлцүүлгийн шатанд байгаа (GIZ-ийн дэмжлэгтэйгээр) ТХГН-ийн тухай шинэ хуульд кластерийн үзэл баримтлалыг тусгах талаар онцгой анхаарч ажиллахыг үнэлгээний баг БОАЖЯ-аас хүсэв.
- Цаашлаад, томилолтын үеэр ажиглагдсан барилгын ажлын чанар өмнөх томилолттой харьцуулахад илт сайжирсан байсан ч зөвхөн “Монгол улсын дундаж” гэж тооцож болохоор тул илүү сайжруулах шаардлагатайг Үнэлгээний баг хэлэв. ТХН-ээс цаашдын барилгын ажлын чанарыг сайжруулах, хүлээн зөвшөөрөгдсөн чанарт хүргэх зорилгоор шинээр баригдах барилга бүрийг зураг төсөл боловсруулах алхмаас эхлээд эцсийн хүлээн авах, шалгах, хяналт тавих хүртэлх барилгын ажлын бүх шатанд оролцдог туршлагатай барилгын компанийг сонгон шалгаруулах тендер зарлана.
- ТХН-ийн хүсэлтээр I үе шатыг дуустал ашиглах боломжгүй байсан төсвийг Орчны бүсийн сан эсвэл II үе шат руу шилжүүлэх боломжтой бөгөөд эдгээр саналын дагуу ТХН-ийн хүсэлт гаргаж, KfW зөвшөөрсний үндсэн дээр хийж болох гэдгийг үнэлгээний баг хэлсэн. Одоо явж байгаа худалдан авалт болон аль хэдийн баталгаажсан гэрээний төлбөрийг 2022 онд I үе шатны төсвөөс төлнө. Бүх төлбөрийг хийсний дараа I үе шатны тусгай дансны үлдэгдэл төсвийг Орчны бүсийн санд шилжүүлнэ. Энэ тухай 2021 оны 9-р сарын 9-ний өдрийн KfW банкнаас БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад илгээсэн захидалд дурдагдсан болно.
- Төслийн II үе шатны III бүрэлдэхүүн хэсэгт баруун бүсийн кластерт хамрагдаагүй нэмэлт 7 ТХГН-т дэмжлэг үзүүлэх тухай байдаг. KfW-ийн Үнэлгээний баг ТХН болон Зөвлөх багийн дэмжлэгтэйгээр томилолтын үеэр зочилсон Дарьгангын УТХГ-г экологийн өндөр үнэ цэнэтэй, шувуудын нүүдэлд онцгой ач холбогдолтой тул төслийн хүрээнд сонгох 7 ТХГН-ийн нэг болгохыг санал болгож байна.

2021 оны 11.17 -нд Улаанбаатар хотод гарын үсэг зурав.

БОАЖ яам

Д.Батмөнх


Төслийн үндэсний
захирал



БОАЖ яам

Д.Ганболд

Төрийн нарийн
бичгийн дарга



KfW банкны
Үнэлгээний баг

Майкл Сумсар

KfW банкны

Монгол дахь

суурин төлөөлөгч

